



МОНГОЛ УЛС  
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/166

Чингис хот

Г Гоц халдварт шүлхий өвчнөөс Г  
урьдчилан сэргийлэх хаврын вакцинжуулалтын  
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын вакцинжуулалтын ажлыг тарилга хүлээн авсан өдрөөс эхлэн 10-15 хоногийн хугацаанд чанартай, шуурхай зохион байгуулсугай.

2. Уг ажилд багийн Засаг дарга, төрийн албан хаагчдыг томилон хяналт тавьж ажиллуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангаж, тарилгын дүн, үйлчилгээний хөлсний санхүүжилтийн бичиг баримтыг холбогдох яаманд хугацаанд нь хүргүүлж ажиллахыг Хүнс, Хөдөө аж ахуй газар /Ж.Энх-Амгалан/-т, урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА